

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/115/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Гэрээт аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ТБОНӨХБАҮХАТ</i>	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</i>
<i>ТӨБЗГ</i> <i>УТХО</i>	<i>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Улсын төсвийн хөрөнгө оруулалт</i>
<i>НБББББ</i>	<i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг</i>

## Агуулга

<b>1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ</b> .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	6
2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
/төгрөгөөр/.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	9
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН .....	11
3.АУДИТЫН ТАЙЛАН .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
.....	
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....	19

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗРЫН ДАРГА Ш.НОХОЙЖАВ  
ТАНАА

2021-03-18 № 2/166  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Орон нутгийн өмчийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлийг хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, бүртгэлээр хяналт тавих, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хүлээн авч хяналт, үнэлгээ хийх нэгтгэх болон мэргэжилтний ажилтны ёс зүйн байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын гол асуудал

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, үнэ төлбөргүй нэмэгдсэн хөрөнгө бүртгээгүй, тайлант оны элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, жолоочийн тооцоог бодоогүй, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтуудыг мөрдөөгүй, аудитын "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "тохиолдсон байх", "иж бүрэн байх", "оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

021020711

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОРДБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,660,450</u></b>	<b><u>3,797,450</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,555,671	1,555,671
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,232,819	1,232,819
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	322,852	322,852
3352	Хувь хүмүүсээс авах авлага	322,852	322,852
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	2,104,779	2,241,779
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	2,104,779	2,241,779
35410	Бичиг хэргийн материал	254,000	177,000
35420	Аж ахуйн материал	1,850,779	2,064,779
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>8,053,435,945.40</u></b>	<b><u>7,379,144,307.76</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	8,053,435,945.40	7,379,144,307.76
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	8,053,036,070.44	7,378,858,682.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,490,241,477	10,589,103,491
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,719,057,805.47)	(4,475,333,186.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44,000,000	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(44,000,000)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	199,253,883	206,373,883
39206	Хуримтлагдсан элэгдэл	(134,295,867.05)	(157,405,597.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,215,029	12,595,029
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,232,385.04)	(8,386,674.78)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,211,841,739	1,211,841,739
39217	Ном	70,000	70,000
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	399,875	285,625
39303	Бусад биет бус хөрөнгө	457,000	457,000
39304	Хуримтлагдсан элэгдэл	(57,125.04)	(171,375)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>8,057,096,395.40</u></b>	<b><u>7,382,941,757.76</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>309,907.20</u></b>	<b><u>20,306,001.45</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	309,907.20	20,306,001.45
<b>413</b>	<b>Өглөг</b>	309,907.20	20,306,001.45
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	285,787.55	20,306,001.45
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	24,119.65	-
41361	Байгууллагад төлөх өглөг	24,119.65	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>8,056,786,488.20</u></b>	<b><u>7,362,635,756.31</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,056,786,488.20	7,362,635,756.31
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	8,056,786,488.20	7,362,635,756.31
51210	Өмнөх үеийн үр дүн	8,056,786,488.20	8,056,786,488.20
51220	Тайлант үеийн үр дүн	-	(694,150,731.89)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>8,057,096,395.40</u></b>	<b><u>7,382,941,757.76</u></b>

**2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (Г)</b>	<b>4,120,548,504</b>	<b>354,873,889</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,943,801,304</b>	<b>193,074,389</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,853,045,746	193,074,389
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,840,205,500	177,212,014
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000	4,121,100
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,018,500	74,228,900
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,827,187,000	98,862,014
120005	Түрээсийн орлого	12,840,246	13,612,375
120009	Бусад орлого		2,250,000
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	90,755,558	-
121002	Өмч хувьчлалын орлого	90,755,558	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>176,747,200</b>	<b>161,799,500</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,000,000	9,000,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		9,000,000
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	156,747,200	152,799,500
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,747,200	152,799,500
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>934,874,386.13</b>	<b>1,049,024,620.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>934,874,386.13</b>	<b>1,049,024,620.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	821,946,055.63	971,644,245.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	109,958,882	119,738,759
210101	Үндсэн цалин	87,674,141	94,842,986.55
210102	Нэмэгдэл	19,769,141	18,680,772.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,515,600	6,215,000
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,744,860.28	15,177,344.90
210201	Тэтгэврийн даатгал	9,346,505	10,320,594.54
210202	Тэтгэмжийн даатгал	1,099,588.82	1,214,187.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	879,671.07	971,350.06
210204	Ажилгүйдлийн даатгал	219,917.75	242,837.53
210205	Эрүүл мэндийн даатгал	2,199,177.64	2,428,375.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,000,000	25,000,000
210302	Түлш, халаалт	20,000,000	20,000,000
210303	Цэвэр, бохир ус		

210304	Байрны түрээс	5,000,000.00	5,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,196,408.50	14,823,841.85
210401	Бичиг хэрэг	2,847,500.00	3,968,680.35
210402	Тээвэр, шатахуун	6,960,500.00	8,325,053.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,130,108.50	2,184,108.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,000	60,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,978,600	286,000
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	207,700	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	541,000	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	101,000	-
210604	Урсгал засвар	440,000	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,385,500	1,466,000
210702	Дотоод албан томилолт	4,385,500	1,466,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,675,301	12,831,648
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,929,280	11,882,428
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000	216,000
210803	Даатгалын үйлчилгээ	122,721	77,220
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000	34,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,000	22,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,236,900	600,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,400	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	643,444,103.85	782,606,651.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,953,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	643,444,103.85	780,653,651.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	112,928,330.50	77,380,375.50
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,910,000	1,000,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,910,000	1,000,000
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	111,018,330.50	0.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,018,330.50	0.50
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	76,380,375
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	76,380,375
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>3,185,674,117.87</b>	<b>(694,150,731.89)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,185,674,117.87</b>	<b>(694,150,731.89)</b>

**2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>293,361,504</b>	<b>256,011,875</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>116,614,304</b>	<b>94,212,375</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>25,858,746</b>	<b>94,212,375</b>

120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	13,018,500	78,350,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000	4,121,100
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,018,500	74,228,900
120005	Түрээсийн орлого	12,840,246	13,612,375
120009	Бусад орлого		2,250,000
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	90,755,558	-
121002	Өмч хувьчлалын орлого	90,755,558	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>176,747,200</b>	<b>161,799,500</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,000,000	9,000,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		9,000,000
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	156,747,200	152,799,500
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,747,200	152,799,500
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>293,361,504</b>	<b>256,011,875</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>293,361,504</b>	<b>256,011,875</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>180,463,173.50</b>	<b>178,631,499.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	103,972,949	95,848,900
210101	Үндсэн цалин	84,313,849	63,614,172
210102	Нэмэгдэл	17,143,500	25,499,128
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,515,600	3,735,600
210104	Урамшуулал	-	3,000,000
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10,994,100	12,939,600
210201	Тэтгэврийн даатгал	7,476,100	9,105,600
210202	Тэтгэмжийн даатгал	879,500	958,500
210203	ҮОМШӨ-ний даатгал	703,600	766,800
210204	Ажилгүйдлийн даатгал	175,900	191,700
210205	Эрүүл мэндийн даатгал	1,759,000	1,917,000
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,000,000	25,000,000
210302	Түлш, халаалт	20,000,000	20,000,000
210304	Байрны түрээс	5,000,000	5,000,000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,374,342.50	14,959,961.50
210401	Бичиг хэрэг	2,850,899.50	3,890,800
210402	Тээвэр, шатахуун	6,960,500	8,325,053
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,192,290	2,184,108.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,000	60,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,298,653	500,000
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000	-
210604	Урсгал засвар	500,000	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,479,524	2,620,818
210702	Дотоод албан томилолт	7,479,524	2,620,818

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,142,258	17,809,220
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,168,137	16,860,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000	216,000
210803	Даатгалын үйлчилгээ	122,721	77,220
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000	34,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,000	22,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,476,400	600,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,453,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,453,000
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>112,898,330.50</b>	<b>77,380,375.50</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,880,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,880,000.00	1,000,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>111,018,330.50</b>	<b>0.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,018,330.50	0.50
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>76,380,375</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	76,380,375

#### 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,871,112,423.33	4,871,112,423.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,871,112,423.33	4,871,112,423.33
C07	Тайлант үеийн үр дүн	3,185,674,064.87	3,185,674,064.87
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,056,786,488.20	8,056,786,488.20
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,056,786,488.20	8,056,786,488.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,056,786,488.20	8,056,786,488.20
D08	Тайлант үеийн үр дүн	(694,150,731.89)	(694,150,731.89)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,362,635,756.31	7,362,635,756.31

#### 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	150,717,600	156,100,173.5	156,963,100	156,920,599.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	150,717,600	155,780,173.5	156,963,100	156,920,599.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	148,717,200	153,900,173.5	155,963,100	155,920,599.5
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	79,064,700	87,762,484	95,848,900	95,848,900
210101	Үндсэн цалин	59,405,600	65,477,743	63,614,200	63,614,200
210102	Нэмэгдэл	17,143,500	19,769,141	25,499,100	25,499,100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,515,600	2,515,600	3,735,600	3,735,600

210104	Урамшуулал			3,000,000	3,000,000
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	9,883,000	10,997,245	12,939,600	12,939,600
210201	Тэтгэврийн даатгал	6,720,500	7,545,145	9,105,600	9,105,600
210202	Тэтгэмжийн даатгал	790,600	813,600	958,500	958,500
210203	ҮОМШӨ-ний даатгал	632,500	703,700	766,800	766,800
210204	Ажилгүйдлийн даатгал	158,100	175,800	191,700	191,700
210205	Эрүүл мэндийн даатгал	1,581,300	1,759,000	1,917,000	1,917,000
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,000,000	25,000,000	25,000,000	25,000,000
210302	Түлш, халаалт	20,000,000	20,000,000	20,000,000	20,000,000
210304	Байрны түрээс	5,000,000	5,000,000	5,000,000	5,000,000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,776,600	12,255,689.50	13,217,200	13,196,061.50
210401	Бичиг хэрэг	2,850,900	2,850,899.50	2,230,900	2,850,900
210402	Тээвэр, шатахуун	6,960,500	6,960,500	8,352,600	7,732,053
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,393,200	2,192,290	2,061,700	2,053,109
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,000	72,000	72,000	60,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000	180,000	500,000	500,000
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000	500,000	-	-
210604	Урсгал засвар	500,000	500,000		
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11,242,900	7,485,497	2,267,000	2,266,818
210702	Дотоод албан томилолт	11,242,900	7,485,497	2,267,000	2,266,818
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,250,000	9,899,258	6,690,400	6,669,220
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,300,000	8,290,137	5,720,100	5,720,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000	150,000	216,000	216,000
210803	Даатгалын үйлчилгээ	375,000	134,121	77,300	77,220
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000	180,000	55,000	34,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,000	45,000	22,000	22,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,000	1,100,000	600,000	600,000
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,000,400	1,880,000	1,000,000	1,000,000
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,000,400	1,880,000	1,000,000	1,000,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,400	1,880,000	2,000,000	1,000,000
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>320,000</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	320,000	-	-
223001	Бусад хөрөнгө		320,000		
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	150,717,600	156,100,173.5	156,963,100	156,920,599.5
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	146,717,600	152,100,173.5	152,963,100	152,799,499.5
132001	Орон нутгийн төсвөөс	146,717,600	152,100,173.5	152,963,100	152,799,499.5
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	4,000,000	4,000,000	4,000,000	4,121,100
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000	4,000,000	4,000,000	4,121,100

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	132,614,304	96,841,275
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	26,243,000	96,841,275
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	26,243,000	96,841,275
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	16,201,347	-
210101	Үндсэн цалин	16,201,347	
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,798,653	1,170,900
210401	Бичиг хэрэг		1,039,900
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		131,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,798,653	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	7,500,000
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,500,000
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,243,000	10,290,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,878,000	10,290,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,365,000	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	1,500,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,500,000
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	106,371,304	76,380,375
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	106,371,304	76,380,375
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	132,614,304	96,841,275
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	132,614,304	96,841,275
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000	87,841,275
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	112,614,304	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		9,000,000

## 3.АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. Ерөнхий зүйл

Орон нутгийн өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Ш.Нохойжав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд эм, бичиг хэрэг, аж ахуйн материал болон шатахууны худалдан авалт зарцуулалт, үндсэн хөрөнгө, улирлын мөнгөн урамшуулал, илүү

цаг олголт, дотоод хяналт, тооллого хийж тооцоо бодох талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 16-наас 2021 оны 03 дугаар сарын 18-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь Ковид -19 цар тахлын үеийн хөл хорио тогтоолт, нягтлан бодогчийн ажлын хариуцлага сулаас 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2021 оны 03 сарын 10-ны өдөр Төрийн аудитын байгууллагад ирүүлж хуулийн хугацаа хоцроосон болно.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орон нутгийн өмчийн газар нь “төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтыг хариуцах, бүртгэлээр хяналт тавих, төрийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулах, стратеги төлөвлөгөөг батлах, төрийн өмчийг хувьчлах, хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах, төрийн өмчийн улсын үзлэг, тооллого хийх, орон нутгийн өмчийн асуудлаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах талаарх стратеги болон бүтцийн загварыг тодорхойлно” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны чиглэл нь дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын эзэмшилд байгаа барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалтад өмч эзэмшлийн гэрээ байгуулан хяналт тавих, гэрээ дүгнэх
- Өмчийн бүртгэл, тооллого явуулах, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, үндсэн хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах, олж авах саналыг хянаж шийдвэрлүүлэх,
- Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлийг хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, бүртгэлээр хяналт тавих, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хүлээн авч хяналт, үнэлгээ хийх нэгтгэх
- Орон нутгийн өмчийн барилга, байгууламж, эд хөрөнгийг түрээслүүлэх, гэрээг батлах, түрээсийн орлогыг орон нутгийн төсөв, хуулийн этгээдийн дансанд оруулах ажлыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулах, үр дүнг тайлагнах, өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орон нутгийн өмчийн газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагааг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй, аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 822260.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 8222.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 354873.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3548.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орон нутгийн өмчийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 674154.6 мянган төгрөгөөр буюу 8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	1,555.7	1,555.7	-
Бараа материал	2,104.8	2,241.8	137.0
Үндсэн хөрөнгө	8,053,435.9	7,379,144.3	(674,291.6)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,057,096.4</b>	<b>7,382,941.8</b>	<b>(674,154.6)</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>309.9</b>	<b>20,306.0</b>	<b>19,996.1</b>
Цэвэр хөрөнгө, өмч	8,056,786.5	7,362,635.8	(694,150.7)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,057,096.4</b>	<b>7,382,941.8</b>	<b>(674,154.6)</b>

Авлага дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2241.8 мянган төгрөг болж өссөн нь аж ахуйн материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэнээс шалтгаалжээ.

№	Үзүүлэлт	Дүн
1	<b>Оны эхний үлдэгдэл</b>	2,104.8
2	Нэмэгдсэн	13,450.7
2.1	Худалдан авсан	13,450.7
3	Хасагдсан	13,313.7
3.1	Худалдсан, зарцуулсан	13,313.7
4	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>2,241.8</b>

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 11958079.1 мянган төгрөг, оны эцэст 12020441.1 мянган төгрөг болж 62362.0 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын паркийн хуучин хүүхдийн тоглоомын засварыг 98862.0 мянган төгрөгөөр хийгдсэнээс нэмэгдсэн, аймгийн ИТХ-ын тогтоолоор газарт тээврийн хэрэгслийг акталсантай холбоотой хасагдсан байна.

№	Үзүүлэлт	Дүн
1	<b>Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b>	<b>11,958,079.1</b>

2	Нэмэгдсэн	106,362.0
2.1	Худалдан авсан	7,500.0
2.2	Бусад	98,862.0
3	Хасагдсан	44,000.0
3.1	Акталсан	44,000.0
4	<b>Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	12,020,441.1
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	3,904,643.2
801	Элэгдлийн зардал тайлант хугацааны	780,653.6
	Дансны хасалт	44,000.0
10	Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	4,641,296.8
11	<b>Үлдэгдэл өртөг</b>	7,379,144.3

Өр төлбөр оны эцэст 20306.0 мянган төгрөг болж 19996.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн гол шалтгаан нь цалинтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварт төлөх өр буюу эм, хүнсний болон бичиг хэргийн материалын өглөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7362635.8 мянган төгрөг болж 694150.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 694150.7 мянган төгрөгийн алдагдалтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Орон нутгийн өмчийн газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3765674.6 мянган төгрөгөөр буюу 91.4 хувиар буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3765674.6 мянган төгрөгөөр буюу 91.4 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь өмнөх онд 3728325.0 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй Эвийн зөийн хүч битүү захын барилга бүртгэж авсан нь нөлөөлсөн байна. Мөн 121.1 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны орлого, 772.2 мянган төгрөгөөр түрээсийн орлого, бусад орлого 2250.0 мянган төгрөгөөр тус тус өссөн 3947.7 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 11000.0 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого, туслах үйл ажиллагааны орлого 25545.2 мянган төгрөгөөр тус тус буурсан зэрэг нөлөөлсөн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	4,120,548.5	354,873.9	(3,765,674.6)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000.0	4,121.1	121.1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,827,187.0	98,862.0	(3,728,325.0)
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	99,774.1	74,228.9	(25,545.2)
Түрээсийн орлого	12,840.2	13,612.4	772.2
Бусад орлого		2,250.0	2,250.0
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	156,747.2	152,799.5	(3,947.7)
Нэмэлт санхүүжилтийн орлого	20,000.0	9,000.0	(11,000.0)

Нийт зардал өмнөх оноос 114150.2 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд тус тус өссөн, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, томилолтын зардал, урсгал шилжүүлгийн зардлууд буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн холбоотой байна.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
	<b>2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	934,874.4	1,049,024.6	114,150.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,958.9	119,738.8	9,779.9
2102	Ажил олгогчоос даатгалд төлөх	13,744.9	15,177.3	1,432.4

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,000.0	25,000.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	16,196.4	14,823.8	(1,372.6)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	541.0		(541.0)
2107	Томилолт, зочны зардал	4,385.5	1,466.0	(2,919.5)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	8,675.3	12,831.6	4,156.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	643,444.1	782,606.7	139,162.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,928.3	77,380.4	(35,547.9)

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 212021.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 212021.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 156963.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 152963.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээс, 4000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн санхүүжилт 152799.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 4121.1 мянган төгрөг, нийт 156920.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 156920.6 мянган төгрөгийг зарцуулж 0.5 мөнгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 156920.6 мянган төгрөг буюу 100 хувьтай зарцуулж, төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээ 0.5 мөнгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар орон нутгаас 9000.0, цахим тендерийн орлого 13125.0, түрээсийн орлого 13612.4, дэнчин, хөрөнгийн дуудлага худалдааны орлого 61103.9 бүгд 96841.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, 20460.9 мянган төгрөгийн зарлага гаргаж, 76308.4 мянган төгрөгийн өмч хувьчлалын орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс, хугацаандаа оруулсан 126 мэдээллийг оруулсан, 26 мэдээлээгүй хугацаа хоцроосон, Шилэн дансны мэдээллийг хянахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого буюу зарлагын мэдээллийг мэдээлээгүй байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	106.0	1	106.0	-	-	100
Албан шаардлага	1	6,960.5			1	6,960.5	
Зөвлөмж	2	397.0	1	397.0	1	-	50
Нийт дүн	4	7,463.5	2	503.0	2	6,960.5	75

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 739739.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 699584.7 мянган төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 19848.9 мянган төгрөгийн зөрчилд , 5785.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6095.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 28274.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа:** Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын 40 тоот тогтоолоор аймгийн орон нутгийн өмчийн данс бүртгэлд байгаа Жаргалант сумын хүүхдийн паркийн хуучин тоглоомуудад хийгдсэн засварыг 98862.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгөд орлого авч бүртгээгүй,
2. Үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн хөрөнгийн орлогын 98862.0 мянган төгрөгөөр санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор бүртгээгүй , мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн дуудлага худалдааны орлогын 2250.0 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй 101112.0 мянган төгрөгийн орлого дутуу бүртгэсэн ,
3. Хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал 299236.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
4. Тайлант үеийн үр дүнг 200374.3 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг аудитын явцад залруулга хийгдлээ.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 699584.7 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 40154.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 5785.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6095.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Хөрөнгө худалдан борлуулсны авлага, орон нутгийн байгууллагууд хөрөнгө өмчийг түрээслүүлсний орлогын 30 хувийг орон нутгийн өмчийн сангийн дансанд төвлөрүүлээгүй 4351.5 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй, тус газарт хэдэн байгууллага ямар хөрөнгийг түрээслүүлж байгаа талаар нарийн судалгаагүй, жолоочийн замын тооцооны хуудсанд газрын дарга нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ажилд явсан нь тодорхой бус 1433.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл

ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , " 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" , ТӨБЗГазрын 293 тоот тогтоолын 4.2-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр ашиглаж буй этгээдийн түрээсийн төлбөр болон улсын төвлөрүүлэх орлогыг гэрээний дагуу тухай бүр бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авах", түрээсийн гэрээний 3.5-д "түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 30 хувийг төлбөр орсноос хойш ажлын 5 хоногт дотор улсын төсөвт төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй, аудитын "үнэн зөв байдал", "тодруулга ба тодруулга", "бодитой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилтэй холбоотой 5785.1 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт

2. Тайлант онд 6095.1 мянган төгрөгийн шатахуун тослох материалыг олгохдоо шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугааргүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын баримт, нэхэмжлэл бүрэн бус, нягтлан бодогч нь жолоочийн тооцоо бодоогүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ" , гэсэн заалттай нийцээгүй, аудитын "тодруулга ба тодруулга", "хэмжилт", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 28274.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалгүй байна.

### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1.Өглөгийн данстай холбоотой асуудал:**

1.1 Илрүүлэлт: Тайланд онд үүссэн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар болон цалинтай холбоотой өглөгийг жилийн эцэст холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, бэлтгэн нийлүүлэгч байгууллага бүрээр тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байх, өглөг дутуу тусгах,

1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , " 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн

нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалтуудыг мөрдөх, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах,

1.4 Байгууллагаас өгсөн хариу: Хүлээн зөвшөөрсөн.

## **2. Бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хариуцагчийн тайлан гаргахтай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Тайланд онд худалдан авсан бараа материалын тайланг эд хариуцагч гаргаагүй, нягтлан бодогч нь санхүүгийн программд холбогдох мэдээллийг оруулдаг, шаардах хуудсанд байгууллагын дарга болон нягтлан бодогч нар гарын үсэг зурж баталгаажуулаагүй зэрэг зөрчил илэрлээ.

2.2. Эрсдэл: Эд хариуцагчийн тайлан гаргаагүй байх, баталгаажуулаагүй шаардах хуудсаар материал зарлагдсан байх

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна" гэсэн заалтыг хэрэгжүүлэн сар бүрийн шатахууны тайлан гаргаж, анхан шатны баримтын бүрэн бүрдүүлэх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

## **3. Орлогын данстай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт: Хөрөнгийн дуудлага худалдааны орлого 2250.0 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан боловч анхан шатны баримтын бүрдүүлээгүй зөрчил байна.

3.2. Эрсдэл: Орлогыг бэлнээр зарцуулсан байх, санхүүгийн тайланд тусгахгүй орхигдуулах, мөнгө дутах

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна." 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалтуудыг мөрдөх, дуудлага худалдааны орлогыг Төрийн сангийн дансанд тухай бүр төвлөрүүлэн ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

## **4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт : Өмнөх СТА-аар байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон НББББичиг боловсруулан батлуулан мөрдөх зөвлөмж өгөгдсөн хэрэгжүүлээгүй дутагдал илэрлээ.

4.2. Эрсдэл: Байгууллагын онцлогт тохирсон НББББичиг боловсруулаагүй байх,

4.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг

баталж, мөрдөж ажиллана", гэсэн заалтыг үндэслэн бодлогын баримт бичиг боловсруулан газрын даргын тушаалаар батлуулан ажиллах,

**4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

**5. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**5.1. Илрүүлэлт:** shilendans.gov.mn цахим сайтад 26 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг байршуулаагүй байна.

**5.2. Эрсдэл:** Холбогдох мэдээллийг ил тод мэдээлээгүй байх, хугацаанд байршуулаагүй байх

**5.3. Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-д “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;”, 6.1.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 3.2.14.-д "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар;”, 3.1.16-д “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар” гэсэн заалтыг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулан ажиллах,

**5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

Огноо: 2021	Аудитын нэр: Орон нутгийн өмчийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ХОА-2021/115/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Орон нутгийн өмчийн газар	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Албан тушаал
1	2	3	4	5	6
1	Жаргалант сумын хүүхдийн паркийн тоглоомуудыг УТХО-ын хөрөнгөөр хийгдсэн засварыг бүртгээгүй	98862.0	Залруулга хийх	ОНӨ Газрын дарга, нягтлан бодогч	Ш.Нохойжав, Б.Болор-Эрдэнэ
2	Зарим нэр төрлийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй, тайлант оны элэгдлийн зардлыг зөрүүтэй тусгасан	299236.4	Залруулга хийх		
3	Мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд кассаар бэлнээр авч зарцуулсан хөрөнгийг орлогоо хүлээн зөвшөөрч бүртгээгүй	101112.0	Залруулга хийх		
4	Тайлант оны үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн	200374.3	Залруулга хийх		

5	Хөрөнгө худалдан борлуулсны авлага, орон нутгийн байгууллагууд хөрөнгө өмчийг түрээслүүлсний орлогын 30 хувийг орон нутгийн өмчийн сангийн дансанд төвлөрүүлээгүй, авлагаар бүртгээгүй, тус газарт хэдэн байгууллага ямар хөрөнгийг түрээслүүлж байгаа талаар нарийн судалгаагүй, жолоочийн замын тооцооны хуудсанд газрын дарга нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ажилд явсан нь тодорхой бус шатахуун зарцуулсан	5785.1	Төлбөрийн акт		
6	Шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугааргүй, нягтлан бодогч нь жолоочийн тооцоо бодоогүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй	6095.1	Албан шаардлага өгөх		
7	Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	20306.0	Зөвлөмж өгөх		
8	Хөрөнгийн дуудлага худалдааны орлогыг бэлнээр авч зарцуулсан, Төрийн сан банк дахь дансанд төвлөрүүлээгүй	2250.0	Зөвлөмж өгөх	ОНӨ Газрын дарга, нягтлан бодогч	Ш.Нохойж ав, Б.Болор-Эрдэнэ
9	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг <a href="http://shilendans.gov.mn">shilendans.gov.mn</a> цахим сайтад байршуулаагүй зөрчил илэрлээ.		Зөвлөмж өгөх	ОНӨ Газрын дарга, нягтлан бодогч	Ш.Нохойж ав, Б.Болор-Эрдэнэ
10	Тайланд онд худалдан авсан бараа материалын тайланг эд хариуцагч гаргаагүй, нягтлан бодогч нь санхүүгийн программд холбогдох мэдээллийг оруулдаг, шаардах хуудсанд байгууллагын дарга болон нягтлан бодогч нар гарын үсэг зурж баталгаажуулаагүй	5718.7	Зөвлөмж өгөх	ОНӨ Газрын дарга, нягтлан бодогч	Ш.Нохойж ав, Б.Болор-Эрдэнэ
11	Өмнөх СТА-аар байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон НББББичиг боловсруулан батлуулан мөрдөх зөвлөмж өгөгдсөн хэрэгжүүлээгүй		Зөвлөмж өгөх	ОНӨ Газрын дарга, нягтлан бодогч	Ш.Нохойж ав, Б.Болор-Эрдэнэ
<b>ДҮН</b>		739739.6			

## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР